

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛӨӨС ӨГӨХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот

2025 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

АГУУЛГА

УДИРТГАЛ	2
МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ	2
1.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал.....	3
1.2. Төсвийн орлого	4
1.3. Төсвийн зарлага	5
1.4. Төсвийн хөрөнгө оруулалт.....	8
1.5. Өрийн удирдлагын стратегийн талаар.....	9
ЗӨВЛӨМЖ:	12
ЭХ СУРВАЛЖ	13
Зураг 1. Монгол Улсын төсвийн зарлага, инфляцын хамаарал	4
Зураг 2. ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлага ба урсгал зардлын хувь, 2018-2025 оноор	6
Зураг 3. ДНБ-д төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь	8
Хүснэгт 1. Макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн таамаглалын харьцуулалт	3
Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн зарлагын үзүүлэлт.....	6

УДИРТГАЛ

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16¹.5.2-д заасны дагуу Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-өөс Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн төсөлд шинжилгээ хийж, холбогдох дүгнэлтийг өгч байна.

ТТБЗ нь 2024 оны 1 дүгээр сараас өнөөгийн бүтэц бүрэлдэхүүнтэй, байнгын үйл ажиллагаатай болж эхэлснээс хойш өөрийн үндсэн үүрэг болох төсвийн тогтвортой байдлыг хадгалах асуудлын хүрээнд Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн төсвийн бодлогын гол баримт бичиг болох Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл (ДХТХМ)-д дүгнэлт, зөвлөмжийг өгч ирсэн.

ТТБЗ-ийн баримталж буй бодлогын гол чиглэл нь:

- Монгол Улсын төсвийн бодлого нь мөчлөг сөрсөн, макро эдийн засгийн зорилго, тогтвортой өсөлтийг дэмжсэн байх;
- Төсвийн тэлэлтийг багасган төсвийн тогтвортой байдлыг бий болгох нөхцөлийг бүрдүүлэх, ДНБ-д эзлэх төсвийн орлого, зарлага, өр төлбөрийн тэнцвэртэй байдлыг хангах, төсөвт тулгарч болзошгүй эрсдэлийг бууруулах;
- Төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын оновчтой байдлыг хангах, ДНБ-д эзлэх нийгмийн халамжийн зардлын хувь хэмжээг багасгах замаар төсвийн зарлагын бодлогыг сайжруулах зэрэг гол чиглэлд төвлөрч байна.

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн ДХТХМ-ийн төсөл нь Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал, ТТБЗ-өөс 2025 оны 3 дугаар сарын 14-ны өдөр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал”-ын тайланд тусгагдсан эдийн засгийн таамаглал, дүгнэлт зөвлөмж, гадаад дотоод эдийн засгийн нөхцөл байдалд нийцтэй эсэхийг харгалзан энэхүү дүгнэлтийг гаргаж байна.

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2026 ОНЫ ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ, 2027-2028 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ ДҮГНЭЛТ

Төслийн баримт бичигт дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого нь макро эдийн засгийн болон татварын тогтвортой орчныг бүрдүүлэх, төсвийн урсгал зардлын тэлэлтийг хязгаарлах, төсвийн тусгай шаардлагыг хангах замаар эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн дунд хугацааны төсвийн бодлого стратегийн зорилт гэж тодорхойлж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын хэмжээ 2026 онд 33,479.5 тэрбум төгрөг, 2027 онд 35,628.6 тэрбум төгрөг, 2028 онд 39,086.0 тэрбум төгрөг, энэ хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага 2026 онд ДНБ-ий 31.7 хувь, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувь болж үе шаттай буурч, дунд хугацаанд нэгдсэн төсөв алдагдалгүй байхаар тооцжээ (МУЗГ, 2025).

Энэ нь өнгөрсөн жилүүдэд хэт тэлсэн төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах бодлогод чиглэсэн байгаа нь өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд нийцтэй бөгөөд эрсдэлийг бууруулахад нөлөөлөх үр дүнтэй зорилт бодлого болсон гэж ТТБЗ үзэж байна. Хэдийгээр ийнхүү дунд хугацааны төсвийн бодлогын хувьд өмнөх жилүүдтэй харьцуулахад бодлогын чиглэл сайжирсан ч анхаарах дараах зарим асуудлууд байна.

1.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал

ТТБЗ-өөс 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулахад баримтлах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал”-ын тайланд тусгагдсан макро эдийн засгийн таамаглалын үндсэн агуулга нь Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдалд төсвийн тэлэлтийг цааш үргэлжлүүлэх нь эдийн засгийн таатай нөхцөл байдлыг бий болгохгүй гэсэн санаа байсан.

Новкаст хийхдээ 2025 оныг хэт өндөр төсөөлсөн байна. ДХТХМ-ийн хувьд анхаарах ёстой нэг чухал асуудал нь 2026 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн таамаглалын хувьд гадаад худалдааны тэнцлээс бусад үзүүлэлтүүд нь бидний болон олон улсын байгууллагуудын тооцоолсон таамаглалаас өндөр байна. Түүнчлэн 2025 оны хувьд эдийн засгийн өсөлт 7.5%, нийт экспорт 17.1 тэрбум ам. доллар (уул уурхайн экспорт 15.8 тэрбум, бусад 1.3 тэрбум) гэсэн нь 2025 оны эхний хэдэн сарын ерөнхий төлөвтэй харьцуулахад хэт өндөр төсөөлөл болжээ.

2026 оны эдийн засгийн өсөлт, нэрлэсэн ДНБ, экспорт болон импортын төсөөлөл анхаарал татахуйц байна. Эдийн засгийн өсөлтийг 6.0 хувь, нэрлэсэн ДНБ-ийг 105.6 их наяд төгрөг, нийт экспортыг 18 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн нь ТТБЗ-ийн болон олон улсын байгууллагын тооцоолсон төсөөллөөс өндөр, импортыг 14.2 тэрбум ам. доллар гэсэн нь бага байна.

Хүснэгт 1. Макро эдийн засгийн зарим үзүүлэлтүүдийн таамаглалын харьцуулалт

Үзүүлэлтүүд, 2026	ЭЗХЯ, Өргөн мэдүүлсэн төсөл, 2025 оны 4-р сар	ТТБЗ-ийн боловсруулсан таамаглал, 2025 оны 3-р сар	ОУВС-ийн “World Economic Outlook”-ийн таамаглал, 2025 оны 4-р сар
Эдийн засгийн өсөлт	6.0 %	5.4 %	5.8 %
Нэрлэсэн ДНБ	105.6 их наяд төгрөг	97.2 их наяд төгрөг	106 их наяд төгрөг
Экспорт	18 тэрбум ам.доллар	17 тэрбум ам.доллар	Гадаад худалдааны урсгал тэнцэл -2.852 тэрбум ам. доллар
Импорт	14.2 тэрбум ам.доллар	15.1 тэрбум ам.доллар	

Эх сурвалж: ТТБЗ, ЭЗХЯ


Төслүүдэд суурилсан төсөөлөл хийгдсэн нь эрсдэл дагуулж байна. 2026 оны макро эдийн засгийн тооцооллыг өндрөөр төсөөлөхдөө алт (Баянхөндийн төсөл), ураны олборлолт болон экспорт нэмэгдэх, эрчим хүч, дэд бүтцийн зэс хайлуулах үйлдвэр, гангийн үйлдвэр, нүүрс химийн цогцолбор зэрэг нэр бүхий төслүүд бүгд хэрэгжих, мөн ХАА-н салбарт хэрэгжиж буй хэдий ч макро эдийн засагт төдийлөн нөлөөлөхгүй байгаа зарим төслүүдийн үр дүн 2025 болон 2026 онд гэнэт нөлөөлнө гэж үзсэн нь эрсдэл дагуулж байна.

Монгол Улсын төсвийн зарлага Колин Кларкийн критик хязгаарыг давсан байдалтай хэвээр байна. Английн эдийн засагч Колин Кларк 1945 онд төсвийн зардлын ДНБ-д эзлэх хувь 25%-аас дээш гарсан үед төсөв баланстай байсан ч гэсэн инфляцыг өдөөдөг болохыг судлан тогтоожээ.¹ (Colin Clark, 1945) Монгол Улсад 1997 оноос эхлэн төсвийн зардал Кларкийн хязгаарыг тогтмол давсан байдалтай байна. Төсвийн зарлага ба инфляцын хувьд

¹ Colin Clark, "Public Finance and Changes in the Value of Money", *The Economic Journal*, Vol. 55, No. 220 (December 1945), pp. 371–389.

2000-2024 онд дундаж инфляц 8.8%, төсвийн зарлагын ДНБ-д эзлэх хувь дунджаар 34%, урсгал зардлын эзлэх хувь дунджаар 25% байжээ.

Зураг 1. Монгол Улсын төсвийн зарлага, инфляцын хамаарал



Эх сурвалж: ТТБЗ-ийн 2025 оны таамаглал

Ялангуяа сүүлийн жилүүдэд төсвийн зарлагын хувьд хэмжээ өндөр байгаа нь төсвийн зарлагын эдийн засгийн нөлөөлөл, үр ашгийг тооцох шаардлагыг бий болгож байна.

1.2. Төсвийн орлого

Хуулийн төсөлд “Төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2011-2020 онд дунджаар 29 хувь байсан бол 2021-2024 онд 35.2 хувьд хүрч өссөн байна. Цар тахлын дараах эдийн засгийн идэвхжил, 2022-2023 оны түүхий эдийн үнийн өсөлтөөс хамаарсан төсвийн орлогын огцом өсөлтийн хурд цаашид саарах төлөвтэй байна. Тухайлбал, гадаад орчин талаас дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал, худалдааны дайн болон нүүрсний дэлхийн зах зээлийн үнийн уналт төсвийн орлогод сөргөөр нөлөөлөхөөр байна. Эдгээр хүчин зүйлсийг харгалзан төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээг Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн ирүүлсэн таамаглалаас доогуур төсөөллөө” гэжээ (МУЗГ, 2025, хууд. 58). Үүнийг ТТБЗ-ийн зүгээс төсвийн орлогын хэт өөдрөг төлөвлөлтөөс татгалзсан, түүнийг дагаж төсвийн зарлага өсөх нөхцөлийг хязгаарласан бодлогын сайн эхлэл хэмээн үзэж байна.

Төсвийн орлогын төсөөлөл бодитой болох эхлэл тавигдсан байна. Хуулийн төсөлд “Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагын дагуу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2026 онд 33,479.5 тэрбум төгрөгт хүрэхээр тооцлоо. Мөн “Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгагдсан төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн таамаглалын хязгаарт багтаж байгаа бөгөөд 2026 оны төсөөллөөс 4.0 нэгж хувиар бага буюу 31.7 хувь, 2027 онд 5.3 нэгж хувиар бага буюу 30.4 хувь, 2028 онд 6.2 нэгж хувиар бага буюу 29.6 хувьд хүрэхээр тооцсон” гэсэн нь төсвийн орлогын өөдрөг төсөөллийн алдааг залруулсан байна гэж харж байна. Энэ нь өнөөгийн эдийн засгийн гадаад орчин

тодорхойгүй, дотоодын эдийн засгийн өсөлт саарч болзошгүй байгаа энэ үед ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Голлох эрдсийн бүтээгдэхүүний үнийн таамаглал хүлээлтэд нийцтэй байна. Хуулийн төсөлд нүүрсний үнийг 2026 онд 80, 2027-2028 онд 77 байхаар төсөөлсөн. Энэ нь олон улсын байгууллагын нэг жилийн хугацаанд нүүрсний үнэ өсөхгүй, цаашид дунд хугацаанд хэвээр байх таамаглалтай нийцтэй байгаа. Төсөлд үнийг дээрх байдлаар тооцсон нь эрдсийн бүтээгдэхүүний үнийг хэт өөдрөг төсөөлж төсвийн орлогыг өндөр төлөвлөх өмнөх жилийн хандлага засарч байгаагийн илрэл гэж үзэж байна.

Эдийн засгийн өсөлтийг өндрөөр тооцох хандлага хэвээр байна. Хуулийн төсөлд “Эдийн засгийн өсөлт 2025 оны эцэст 7.5 орчим хувь байхаар тооцоолж байна”, “Эдийн засгийн өсөлт 2026 онд 6.0 хувь, 2027 онд 6.5 хувь, 2028 онд 6.5 хувь орчимд байх төлөвтэй байна. Уул уурхайн салбарт зэсийн баяжмал үйлдвэрлэл, нүүрс, төмрийн хүдэр болон алтны олборлолт нэмэгдэж, салбарын өсөлт 2026 онд 10 орчим хувьд хүрч, эдийн засгийн өсөлтийг 1.5 нэгж хувиар нэмэгдүүлэхээр байна” гэж тооцож гол өсөлтийн хүчин зүйлс нь уул уурхайн салбар болон Засгийн Газраас хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдэд төвлөрнө хэмээн үзжээ. Энэ нь 2025 оны хувьд ТТБЗ-ийн таамаглалаас ихээхэн өндөр байгаа төдийгүй олон улсын байгууллагуудын тооцоолсон таамаглалаас ч өндөр тоо юм. Ингэснээр суурь оны нөлөөллөөр 2026-2028 оны төсвийн орлого, зарлага өндөр гарахад нөлөөлж байгааг анхаарах шаардлагатай.

Зарим эрдсийн бүтээгдэхүүний гарцыг хэт өөдрөг төсөөлсөн нь эрсдэл дагуулж болзошгүй. Хуулийн төсөлд алтны экспортыг “2026 онд 20 тонн, 2027-2028 онд 24 тоннд хүрч нэмэгдэхээр байна” хэмээн таамагласан. Энэ нь Алт хөтөлбөр, болон Баянхөндий төслийн үр дүнтэй холбоотой байна хэмээн үзсэн нь өнөөгийн бодит төлөвлөгөө гүйцэтгэлтэй харьцуулахад хэт өндөр төдийгүй тухайн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, эрсдэлтэй холбоотой тул бодитой байдалд нийцтэй байх магадлал бага байна.


Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тэнцвэржүүлсэн үнээр тооцох аргачлалыг эргэн харах шаардлагатай. Нэгдсэн төсвийн орлогын түүхий эдийн тэнцвэржүүлсэн үнийг тооцохдоо ОУВС-аас түүхий эдийн үнийн мэдээллийг авч ашиглан Австрали, Өмнөд Африкийн нүүрсний үнийг хамруулсан нүүрсний үнийн индексийн дунджийг авч ашиглан 2026 онд нүүрсийг тонн тутмыг 133.7 ам.доллар, 2027 онд 135.8 ам.доллар, 2028 онд 138 ам.доллараар, зэсийн үнийг 2026 онд 8341.8 ам.доллар, 2027 онд 8,428.2ам.доллар, 2028 онд 8,438.8 ам.доллараар тус тус тооцжээ. Энэ нь Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 2026-2028 оны төсөөллийг өндрөөр тооцоход голлон нөлөөлсөн байна. Энэ нь цаашид нэгдсэн төсвийн орлого тэнцвэржүүлсэн орлогодоо хүрэхгүй байх, баялгийн сангийн хөрөнгийн хуваарилалтыг эргэлзээтэй байдалд орох нөхцөлийг бүрдүүлэхээр байна.

1.3. Төсвийн зарлага

ДХТХМ-ийн төслийн баримт бичигт төсвийн зарлагын талаар баримтлах бодлого нь зардлын тэлэлтийг хязгаарлах явдал гэж тодорхойлж, “Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлагын хэмжээ 2026 онд 33,479.5 тэрбум төгрөг, 2027 онд 35,628.6 тэрбум төгрөг, 2028 онд 39,086.0 тэрбум төгрөг байхаар тооцов. Энэ хүрээнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага 2026 онд ДНБ-ий 31.7 хувь, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувь болж үе шаттай буурч, дунд хугацаанд нэгдсэн төсөв алдагдалгүй байхаар төлөвлөсөн болно гэжээ” (МУЗГ, 2025). Энэ нь төсвийн зардлын гол үзүүлэлтүүдийг бууруулахаар тооцсон, дунд хугацаанд төсвийн урсгал зардлын ДНБ-д

эзлэх хувийг үе шаттайгаар бууруулж, 2028 онд 22 хувьд хүргэхээр тооцсон нь төсвийн зарлагын бодлогын хувьд эерэг бодлогын өөрчлөлт гэж үзэж байна. Учир нь, сүүлийн жилүүдэд төсвийн зарлага огцом тэлж цаашид энэ тэлэлтийг үргэлжлүүлэх нь төсвийн орлогын өсөлт төсвийн тогтвортой байдлыг хангахад тодорхой эрсдэлийг дагуулж болзошгүй байсан.

Зураг 2. ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлага ба урсгал зардлын хувь, 2018-2025 оноор



Эх сурвалж: (Сангийн яам, 2024)

Дараах хүснэгтээс төсвийн зарлагын эдийн засаг дахь нөлөөллийг харж болохоор байгаа бөгөөд үүнийг нийт зарлага, урсгал зардлын хэмжээнд бууруулах нь бодлогын хувьд зөв эхлэл юм.

Хүснэгт 2. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн зарлагын үзүүлэлт

№	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	2026	2027	2028
1	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	33,479.5	35,628.6	39,086.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	31.7	30.4	29.6
2	Нэгдсэн төсвийн суурь зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	30,314.5	33,282.2	36,442.0
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	28.7	28.4	27.6
3	Урсгал зардал	25,320.0	26,983.6	29,084.0
	Өсөлтийн хувь	0.1	6.6	7.8
	ДНБ-д эзлэх хувь	24.0	23.0	22.0

Эх сурвалж: (МУЗГ, 2025)

Түүнчлэн цалин тэтгэвэр тэтгэмжийн бодлогыг хэвээр хадгалж цалин, тэтгэврийг инфляцтай уялдуулан нэмэх, харин нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээний хувьд “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг зорилтот бүлэгт чиглүүлж, инфляцын түвшинтэй уялдуулан зохистой түвшинд олгох ба төрийн үр ашиггүй зардлуудыг бууруулах бодлого баримталсан” гэсэн нь зүйтэй юм.

Зарлагын бодлого зөв чиглэлд эргэж төрийн оролцоог бууруулах нөхцөл хангагдах суурь тавигдаж байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого болон нийт зарлага 2026 онд

ДНБ-ий 31.7 хувь, 2027 онд 30.4 хувь, 2028 онд 29.6 хувь болж үе шаттай буурч, дунд хугацаанд нэгдсэн төсөв алдагдалгүй байхаар төлөвлөсөн нь 2018-2025 оны дундаж түвшин болох 34.3 хувиас доогуур төдийгүй сүүлийн жилүүдийн огцом өсөлтийг хязгаарлах бодлого болж чадна. Иймд ДХТХМ-ийн төслийн ДНБ-ий өсөлтийн таамаглал бодитой байж төсвийн орлого, зарлага, тэнцлийн ДНБ-тэй харьцуулсан хувь хэмжээг хэрэгжилтийн түвшинд хадгалах нь чухал гэдгийг анхаарах хэрэгтэй.

Урсгал зардлыг бууруулах, хэмнэлт бий болгоход чиглэсэн бодлого баримталж эхэлж байна. 2024 оны төсвийн тодотголыг дагалдуулан өргөн барьсан ТТБТХ-д оруулсан нэмэлт өөрчлөлтөөр төсвийн тусгай шаардлагыг өөрчилж урсгал зардлыг 30 байхаар хуульчилсан нь бодлогын хувьд томоохон алдаа байсан гэж ТТБЗ-ийн зүгээс үзсээр байгаа билээ. Учир нь, урсгал зардал нь нэмэхэд хялбар боловч бууруулах, хязгаарлахад ихээхэн бэрхшээлтэй зардал төдийгүй төсвийн үр дүнд, үр ашигт сөргөөр нөлөөлөх магадлал өндөртэй юм. Харин 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2027-2028 оны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд “Нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээг 2026 онд ДНБ-ий 24.0 хувь буюу 2025 оны батлагдсан түвшнээс 2.6 нэгж хувиар бууруулж тооцсон. Дунд хугацаанд төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар бууруулж, 2028 онд 22.0 хувьд хүрэхээр төсөөллөө” гэсэн нь 2018-2025 оны урсгал зардлыг дундаж түвшин болох 26.2-оос бага төдийгүй 2024 онд 28.7 байсан түвшнээс даруй 6 нэгж хувиар бууруулахаар зорьсон зорилт юм. Энэ нь цаашид төсвийн нийт зардлыг тэлэх, урсгал зардлыг үр ашигтай төлөвлөх, хуваарилах суурь нөхцөлийг бий болгоход ихээхэн тус болох өөрчлөлт юм. Энд харин инфляцын түвшнийг хэрхэн бууруулах, инфляц өндөр байгаа үед цалин тэтгэвэр, тэтгэмжийг байнга шууд уялдуулан нэмэх нь хэр оновчтой, зөв эсэхийг анхаарах шаардлагатай.

Дунд хугацаанд баримтлах төсвийн бодлого, стратеги нь макро эдийн засгийн бодлогын чиглэлд зөв хандлагатай болж байна. Бид өнөөг хүртэл эдийн засгийг солонгоруулах, хувийн хэвшлийг дэмжих тухай ярьсан боловч бодит байдалд биеллээ олоогүй нь үнэн юм. Харин энэхүү хуулийн төслийн танилцуулгад “Мөн дунд хугацаанд уул уурхайн салбар дахь татварын орлогыг нэмэгдүүлэх чиглэлийг баримталж, уул уурхайн бус салбарт татварын илүү таатай орчныг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг татаж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Төсвийн сахилга батыг сайжруулан, урсгал зардлын тэлэлтийг хязгаарлаж, төрөөс үзүүлж буй нийгмийн халамж, тусламж, үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, төрийн албан хаагчдын цалин ажлын үр дүн, гүйцэтгэл, инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ” гэсэн нь төсвийн орлого, зарлагын бодлогын зөв хослол гэж үзэж байна. Төсвийн зарлагын чиглэлд төрийн оролцоог бууруулах, чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, салбаруудыг татааснаас чөлөөлөх зэрэг оновчтой зорилтуудыг дэвшүүлжээ. Харин эдгээртэй ойролцоо олон зарчмыг өмнө дэвшүүлж байсан ч хэрэгжилт хангалтгүй байсны шалтгааныг бодитойгоор олж харж хэрэгжилтэд анхаарах шаардлагатай.

Төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн байдлаар тооцож байгаа нь зарлагыг өсгөх, буруу төлөвлөж байгаагийн нэг гол шалтгаан болж буйг харгалзан үзэх шаардлагатай байна. Өргөн барьсан баримт бичгийн дэлгэрэнгүй танилцуулгын 56-р хуудсанд (МУЗГ, 2025) тэнцвэржүүлсэн үнийн талаар тодорхой дурджээ. Түүнчлэн Сангийн яамны тоон мэдээлэл болох тооцооллын хавсралтад төсвийн нийт зарлага цэвэр зээлийн дүнг тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлэн тооцож байгаа нь харагдаж (Зураг 1) байна. Энэ нь төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийг хийсвэр болгох нэг гол нөхцөл болж буйг цаашид анхаарах

шаардлагатай юм. Төсвийн орлогоо зөв тооцоолж, зарлагаа түүнд нийцүүлэх зарчмыг баримтлахыг ТТБЗ-өөс удаа дараа анхааруулж байгаа. Гэтэл одоогийн тэнцвэржүүлсэн үнээр тооцсон орлого бодитой төлөвлөгдөх магадлал багатай тул үүнийг дагаж төлөвлөсөн нийт зарлага, цэвэр зээл нь макро эдийн засгийн өнөөгийн болон дунд хугацааны нөхцөл байдалд нийцтэй бус болох тул цаашид тэнцвэржүүлсэн үнийн тооцооллын аргачлалыг өөрчлөх шаардлагатай байна.


Төсвийн зарлагын бодлогын хэрэгжилтийг хангах шаардлагатай. Хуулийн төсөлд “Эдийн засгийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, зах зээл дэх төрийн оролцоог бууруулах, салбаруудыг татааснаас чөлөөлөх бодлого баримтална” гэсэн нь макро эдийн засгийн хөгжлийн гол бодлогын агуулгын хувьд зөв чиглэл юм. Энэ мэт өмнө тавьж байсан зорилтуудын хэрэгжилт хангалтгүй байсан тул энэ удаад дэвшүүлсэн бодлогын хэрэгжилтийг хангах асуудал нь төрийн оролцоог бууруулах нөхцөл, хэрэгжих боломжийг тодорхойлж болохыг анхаарч ажиллах шаардлагатай.

1.4. Төсвийн хөрөнгө оруулалт

Төслийн баримт бичигт “2025 оны нэгдсэн төсвийн хөрөнгө оруулалтын зардалд нийт 8,340.3 тэрбум төгрөг тусгасан ба нийгэм, эдийн засгийн үр ашигтай, тэргүүлэх ач холбогдол бүхий хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэх зарчим баримталсан болно” гэж тусгасан нь хөрөнгө оруулалтын талаар баримтлах гол бодлогыг илэрхийлж байна.

Сүүлийн 10 жилийн байдлаар авч үзвэл дунджаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ ДНБ-ий 4.2 орчим хувийг эзэлж байна.

Зураг 3. ДНБ-д төсвийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь



Эх сурвалж: (Сангийн яам, 2024, 2025)

УИХ-ын Чуулганаар Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хэлэлцэж баталсны дараа Засгийн газраас Төсвийн ерөнхийлөн захирагч нараар 2026 оны төсвийн зарлагын дээд хязгаарыг хуваарилан тогтоодог. Дунд хугацааны төсвийн бодлогыг хэрэгжүүлэхдээ улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбогдуулан дараах зүйлсийг анхаарах шаардлагатай байна.

Төсвийн хуваарилалтыг оновчтой болгох шаардлагатай. Төсвийн хөрөнгө оруулалт нь хэмжээ зориулалтын хувьд хязгаарлагдмал гэдгийг ойлгож ажиллах. Иймд чухам аль ТЕЗ-д ямар хэмжээний хөрөнгө, төсөв хуваарилагдах вэ гэдэг нь маш чухал юм.

Хөрөнгө оруулалтыг хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан нийцүүлэх. Сангийн яамнаас гаргасан төсвийн гүйцэтгэлийн тоо мэдээллээс авч үзвэл өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд Эрчим хүчний салбарт хуваарилагдсан хөрөнгө буурч ирсэн бол Соёл, урлагийн салбарт хуваарилагдаж буй хөрөнгө төсөв хэд дахин нэмэгдэж иржээ.

УИХ-аас батлан гаргасан “Алсын хараа 2050” хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэд бүтэц, эрчим хүчний салбарт томоохон төслүүдийг хэрэгжүүлэх, тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилтыг дэвшүүлж ирсэн. Өөрөөр хэлбэл, бид хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо авто зам, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түлхүү хөгжүүлэх зорилтыг дэвшүүлдэг боловч бодит байдал дээр төсвийн хуваарилалт нь энэхүү бодлоготой төдийлөн нийцэхгүй, өдөр тутмын олон жижиг асуудалд төсвийн хөрөнгийг тарамдуулан хуваарилж ирсэн байна. Тухайлбал, Эрчим хүчний салбарын нийт хөрөнгө оруулалт 2013 онд 258.0 тэрбум төгрөгт хүрч байсан бол 2022 оны гүйцэтгэлээр 80.0 тэрбум төгрөгт хүрч ***3 дахин буурсан*** бол 2024 онд 203.3 тэрбум болж 1.5 дахин өссөн нь өнөөгийн эдийн засгийн нөхцөлд голлох салбарын хувьд хангалтгүй үзүүлэлт юм. Мөн Зам тээврийн сайдын багцын хөрөнгө оруулалт харьцангуй тогтвортой явж ирсэн бөгөөд бараг өөрчлөлтгүй байна.

Боловсрол, шинжлэх ухааны салбарын хөрөнгө оруулалт 2012 онд 125.0 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 546.9 тэрбум төгрөгт хүрч ***4.4 дахин нэмэгдсэн*** бол Соёлын салбарын хөрөнгө оруулалт 2012 онд 34.0 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 180.4 тэрбум төгрөг болж ***5.3 дахин*** нэмэгджээ. (Хавсралт 1)

Иймээс Урт хугацааны хөгжлийн бодлого, ЗГҮАХ-т тусгагдсан зорилт, Монгол Улсыг 2020-2025 онуудад хөгжүүлэх Үндсэн чиглэл, түүнд нийцүүлэн баталсан Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн зорилтуудыг зөв оновчтой хэрэгжүүлэхийн тулд салбарын сайд нарын төсвийн багцын хуваарилалтыг хөгжлийн бодлого, зорилттой нягт уялдуулан шийдвэрлэх ёстой байсан гэж үзэж байна.

Иймд Төсвийн Ерөнхийлөн захирагч нарын 2026 оны төсвийн хязгаарыг зөв оновчтой хуваарилах асуудлаар УИХ-аас тогтоол гарган Засгийн газарт чиглэл өгөх нь зүйтэй гэсэн саналтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн төсвийн төслийн хамт нэгдмэл байдлаар шийдвэрлэх нь бодлогын зөв сонголт юм. Улсын төсвийн урсгал төсөв болон хөрөнгө оруулалтыг төсвийн гадуурх ямар нэгэн сувгаар дамжуулан зарцуулах бус, харин нэгдсэн нэг төсвийн сувгаар зарцуулах ёстой гэдгийг 2017 онд ОУВС-тай хамтран хэрэгжүүлсэн Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд мөрдлөг болгож ирсэн. Ер нь төсвийн гадуурх олон сувгийг бий болгох нь төсвийн сахилга бат, хяналтыг сулруулдаг болохыг Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын зүгээс байнга анхааруулж ирсэн болно.

1.5 Өрийн удирдлагын стратегийн талаар

“Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн танилцуулгад (Монгол Улсын Засгийн газар, 2025) 2026-2028 онд өрийн удирдлыг хэрэгжүүлэх үндсэн 4 зорилтыг дэвшүүлж хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан байна.

Эдгээрийг хэрэгжүүлснээр “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр Засгийн газрын өрийн багцын эрсдэлийн үзүүлэлтүүд сайжирч, дотоодын санхүүгийн зах зээл идэвхжин, Засгийн

газрын болзошгүй өр төлбөрийн эрсдэлийг бууруулах ач холбогдолтой.” гэж дурджээ. Энэхүү баримт бичгүүд болон өмнөх өрийн удирдлагын стратеги, хэрэгжилттэй холбоотой дараах дүгнэлтүүдийг өгч байна.

Засгийн газрын өрийн ачаалал буурч байгаа хандлагыг үргэлжлүүлэх шаардлагатай.

Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийг баталж, хэрэгжүүлснээр 2016 онд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 93.1 хувьд хүрээд байсан Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн байдлаар 41.8 хувьд, 2017 онд төсвийн нийт зардлын 12.8 хувьтай тэнцэж байсан Засгийн газрын өрийн хүүгийн зардал 2024 оны жилийн эцсийн байдлаар 3.8 хувьд тус тус хүрээд байна. Ийнхүү Засгийн газрын өрийн хэмжээ, зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ буурсан, ойрын хугацаанд төлөх өрийн дарамт бага байгаа зэрэг нь өрийн нөхцөл байдал сайжирсныг илтгэж байгаа нь томоохон эерэг үр дүн юм. Үүнийг цаашид хэрхэн хадгалах, бууруулах асуудлыг өрийн удирдлагын хүрээнд онцгой анхаарах шаардлагатай.

Өрийн удирдлагын стратегид Монгол Улсын нийт өрийн асуудлыг хамруулах шаардлагатай байна.

Танилцуулгад Монгол Улсын гадаад өр 2024 оны байдлаар ДНБ-ны 157 хувьтай тэнцүү байгааг дурдсан. Мөн УИХ-аас 2015 онд батлан гаргасан Өрийн удирдлагын тухай хуулийн 1 дүгээр зүйлд уг хуулийн зорилгыг “Энэ хуулийн зорилт нь өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд өрийн зохистой түвшинг хангах, дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх, Засгийн газар, орон нутаг зээллэг хийх замаар өр үүсгэх, дамжуулан зээлдүүлэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах, тэдгээрийг бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заажээ. Гэтэл стратегийн удирдлагын чиглэл нь зөвхөн Засгийн газрын өрийн асуудлыг хамарсан. Нийт өрийн хэмжээний зохистой түвшин, түүнд Засгийн газрын өрийн эзлэх хувь хэмжээ, хувийн хэвшлийн гадаад өрийн санхүүжилтийн боломж орон зайг хангах тухай асуудал хөндөгдөөгүй байгаа нь Засгийн газрын өрийн удирдлагын бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бүрхэг болгож байна. Танилцуулгад дотоодын аж ахуйн нэгжүүд олон улсын санхүүгийн зах зээлээс санхүүжилт босгох нь нэмэгдэж байгааг дурдсан боловч үүнийг цааш хэрхэн нэмэгдүүлэх, түүнтэй Засгийн газрын өрийн удирдлага хэрхэн уялдах талаар бодлогын шийдэл шаардлагатай гэж үзэж байна. Түүнчлэн Засгийн газрын өрөөс гадна Монголбанкны өр, Төрийн өмчит үйлдвэрийн газруудад бүртгэлээс гадуур үүсч байгаа өрийн асуудал, бартер солилцооны зарчмаар хийгдэж байгаа төлбөр тооцоо зэрэг нь бүхэлдээ анхаарал татсан, нийт эдийн засагт нөлөө үзүүлэх хэмжээний томоохон хүчин зүйл болсоор байгааг анхаарах шаардлагатай.

Өрийн удирдлагын стратегийн зорилтын хамрах хүрээг хумьсан нь стратегийн цаашдын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлнө.

“Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг”-т “Болзошгүй өр төлбөрийн төсөвт үзүүлэх нөлөөллийг үнэлэх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх” гэсэн өрийн удирдлагын хувьд нэн чухал зорилтыг энэ удаагийн өрийн удирдлагын зорилтоос хассан. Танилцуулгад өрийн удирдлагын оновчтой тогтолцоог хэрэгжүүлнэ гэж заасан боловч эрсдэлийг үнэлж, сэргийлэх тогтолцоо нь үүнийг зайлшгүй нэг хэсэг гэж үзэж байна. Үүний улмаас Дунд хугацааны Өрийн стратегийн баримт бичигт цаашид гадаад, дотоод хүчин зүйлээс шалтгаалан өр нэмэгдэж болзошгүй нөхцөлд ямар арга замаар сэргийлэх вэ, өр үүсгэж байгаа эрсдэлт хүчин зүйлийг хэрхэн бууруулах вэ гэсэн арга замыг тодорхойлоогүй сул тал үүсч байна.

Тооцооллын суурийг Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцүүлэх шаардлагатай. Танилцуулгад “Улсын төсөв ДНБ-ний 2 хувьтай тэнцэх хэмжээний алдагдалтай үед дээрх стратегиудыг авч хэрэгжүүлснээр Засгийн газрын өрийн зардал, эрсдэлийн үзүүлэлтүүд дараах байдлаар гарах төсөөлөлтэй байна.” (Монгол Улсын Засгийн газар, 2025, хууд. 16) гэсэн нь Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн ДХТХМ-ийн төсөлд 2026-2028 оны төсөв алдагдалгүй байхаар тооцсонтой зөрчилдөж байна.

ДУГНЭЛТ:

- Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хуулийн төсөл, танилцуулга нь эдийн засаг дахь төрийн оролцоо, төсвийн зарлагыг бууруулахад чиглэсэн нь сүүлийн жилүүдэд төсвийн зарлага огцом тэлж, төсвийн орлого нь зарлагаа нөхөх боломж хязгаарлагдаж байгаа энэ үед бодлогын зөв чиглэл болж байгааг тэмдэглэж байна. Монгол Улсын төсвийн зарлага сүүлийн 10 гаруй жил огцом өссөн нь хөгжиж буй орнуудтай харьцуулахад өндөр байгаа төдийгүй энэ өндөр байдал нь зөвхөн эдийн засаг дахь төрийн оролцоо төдийгүй төсвийн тэнцлийг алдагдалгүй баталсан ч эдийн засагт инфляцыг өдөөх зэргээр макро эдийн засагт сөрөг нөлөөлөл бий болгохыг анхаарах шаардлагатай байна.
- Төрийн эдийн засагт оролцох оролцоог бууруулах замаар төсвийн тогтвортой байдлыг хангах эрсдэлийг бууруулах, эдийн засгийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжих, төсвийн сахилга батыг сайжруулах, татаасгүй болгох зэрэг бодлого нь цаашдын төсвийн бодлого эерэг байх суурь нөхцөлийг бүрдүүлэхэд ач холбогдолтой гэж үзэж байна. Хэдий тийм ч эдгээр бодлогын хэрэгжилтэд анхаарахыг өмнөх бодлого төлөвлөлт сануулж байгааг анхаарах хэрэгжилтийн түвшинд анхаарах нь зүйтэй юм.
- Макро эдийн засгийн 2026-2027 оны тооцоолол таамаглалын хувьд суурь оны эдийн засгийн өсөлтийг хэт өөдрөг төсөөлөх, төлөвлөлтийн эхний жил буюу 2026 оны эдийн засгийн өсөлтөд хэрэгжих төсөл хөтөлбөрт найдсан өөдрөг таамаглал хийсэн зэрэг нь хэрэгжүүлэх бодлогын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүйг анхаарах хэрэгтэй байна.
- Төсвийн орлогын таамаглалын хувьд хэт өөдрөг таамаглах хандлага буурч байгаа нь ирээдүйд тулгарч болох эрсдэлийг бууруулах нөлөөлөлтэй болсон боловч зарим эрдсийн бүтээгдэхүүний үнэ болон биет хэмжээг анхаарах шаардлагатай байна.
- Төсвийн зарлагыг тэлэлтгүй хадгалах байдлаар буюу 2026 оны төсвийн зарлагын хэмжээ 2025 оны төсвийн зарлагатай тэнцүү байхаар төлөвлөгдсөн нь эдийн засгийн тодорхой бус нөхцөл байдалд төсвийн хэт тэлэлттэй бодлого баримтлахыг зогсоох эхлэл болж ТТБЗ-ийн 2024 оноос баримталж ирсэн бодлогын хандлагатай нийцэж байна. Мөн нэгдсэн төсвийн нийт, урсгал зардлын ДНБ-д эзлэх хувийн жинг бууруулах бодлого баримталж төрийн оролцоог бууруулах, чөлөөт зах зээлийг дэмжих, урсгал зардлын тэлэлтийг хязгаарлах зорилтууд дэвшүүлсэн нь оновчтой бодлогын сонголт гэж үзэж байна. Энэ хүрээнд төсвийн тэнцвэржүүлсэн орлогод тооцогдож буй тэнцвэржүүлсэн үнийн нөлөөлөл, суурь оны өөдрөг таамаглалтай холбоотой эрсдэл гарч болзошгүй.
- Төсвийн хөрөнгө оруулалтын хувьд төсвийн хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэхээс илүү хуваарилалтыг оновчтой хийх, нэгдсэн төсвийн хамт хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

- Өрийн удирдлагын стратегид Засгийн газар, төрийн өмчит байгууллагын өр, Монголбанкны своп зэрэг нийт төрийн байгууллагуудын өрийн стратегийг улсын нийт өртэй уялдуулан эдийн засаг, төсөвт үзүүлэх нөлөөлөл, хувийн хэвшлийн гадаад санхүүжилтийн орон зайг хэрхэн дэмжих асуудлыг хамруулах шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ:

- Төсвийн зарлагын тэлэлтийг хязгаарлах, төрийн оролцоог бууруулахад чиглэсэн бодлогыг тууштай хэрэгжүүлэх шаардлагатай гэдгийг бодлого, хэрэгжилтийн түвшинд анхаарч бодит ажил болгох;
- Цаашид төсвийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийн шинжилгээг хийж төсвийн зарлагын зохистой түвшин, хуваарилалтын оновчтой байдлыг бодлогын хувьд шийдвэрлэх;
- Макро эдийн засгийн төлөвлөлтийн хувьд суурь оны хэт өөдрөг төсөөлөл, төслүүдийн хэрэгжилтийн нөлөөлөлд суурилсан тооцооллын бодит байдалд анхаарах;
- Төсвийн орлогын тооцоололд ашиглаж буй тэнцвэржүүлсэн үнийг тооцох аргачлалыг эргэн харж төсвийн орлого, баялгийн сангийн хуваарилалтыг бодитой төлөвлөх;
- Төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээнээс илүү хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдаатай байх, хуваарилалт оновчтой байх тал дээр анхаарах;
- Өрийн удирдлагын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төсөвт үзүүлэх нөлөөлөл эрсдэлийн удирдлагыг тогтолцоог бүрдүүлэх;

----- о О о -----

ЭХ СУРВАЛЖ

- Colin Clark. (1945). *Public Finance and Changes in the Value of Money*. The Economic Journal.
- Монгол Улсын Засгийн газар. (2025). “Засгийн газрын өрийн удирдлагын 2026-2028 оны стратегийн баримт бичиг батлах тухай” улсын их хурлын тогтоолын төслийн танилцуулга. Улаанбаатар: Монгол Улсын Засгийн газар.
- МУЗГ. (2025). *Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл*. Улаанбаатар: МУЗГ.
- Сангийн яам. (2024). *Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлогод хийсэн харьцуулсан шинжилгээ*. Улаанбаатар: Сангийн яам.
- Сангийн яам. (2024). *Тооцооллын хавсралт.2025*. Улаанбаатар: Сангийн яам.
- Сангийн яам. (2025 оны 05 12). *Монгол Улсын нэгдсэн төсөв*. Иргэдийн төсөв: <https://iltod.mof.gov.mn/budget-database/budget-jurisdiction>-ээс Гаргасан
- ТТБЗ. (2022/09). *Монгол Улсын 2025 оны төсвийн тухай, эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай, нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн төслүүдэд ТТБЗ-өөс өгөх дүгнэлт*. Улаанбаатар: ТТБЗ.
- ТТБЗ. (2024). “Монгол улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн төсөлд” өгөх дүгнэлт. Улаанбаатар: ТТБЗ.
- ТТБЗ. (2024). *Монгол Улсын Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд, төлөв байдлын таамаглалын тайлан*. Улаанбаатар: ТТБЗ.
- ТТБЗ. (2024). *Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх дүгнэлт, зөвлөмж*. Улаанбаатар: ТТБЗ.
- ТТБЗ. (2024). *Монгол улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгөх дүгнэлт*. Улаанбаатар: ТТБЗ.
- ТТБЗ. (2024/12). *Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөс өгсөн дүгнэлт*. Улаанбаатар: ТТБЗ.
- ТТБЗ. (2025). *Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглал 2026-2028*. Улаанбаатар: ТТБЗ.

Хавсралт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл Төсвийн Ерөнхийлөн Захирагчдаар /2007-2022/

Төсвийн Ерөнхийлөн Захирагч	2007		2008		2009		2010		2011		2012		2013		2014		2015		2016		2017		2018		2019		2020		2021		2022		2023		2024	
	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.	Төлөв	Гүйц.		
ЗАМ, ГЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД	82.2	59.5	92.4	72.8	138.2	117.1	158.7	126.9	223.7	214.2	593.7	576.1	1,085.1	1,013.1	511.3	482.7	194.9	173.4	758.0	663.3	143.9	127.1	80.8	68.4	241.8	226.1	209.4	190.9	233.6	220.2	230.8	216.0	408.8	396.6	737.1	635.5
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	30.8	27.7	49.5	45.7	36.4	34.1	65.0	62.8	106.9	103.5	140.0	125.0	125.3	84.0	251.1	176.3	109.3	81.3	135.8	121.0	87.6	83.5	212.0	176.9	493.8	439.2	329.0	265.5	364.0	339.5	357.0	291.0	529.3	516.4	723.1	546.9
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	122.4	115.7	81.8	66.3	49.8	42.9	42.1	36.8	117.0	113.2	138.7	131.3	283.6	258.5	345.1	338.7	199.0	197.6	85.1	81.5	113.2	89.3	37.7	36.9	97.2	86.2	32.3	18.4	38.1	36.6	80.9	77.2	169.0	168.8	226.0	203.3
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	38.8	37.9	61.0	57.4	17.3	11.2	34.4	30.5	72.7	71.6	72.2	66.7	135.6	105.2	203.2	168.2	81.9	77.3	128.6	114.9	76.6	68.7	80.5	67.4	141.4	138.5	179.1	141.8	193.3	182.8	223.3	201.7	345.2	336.9	413.8	349.8
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	1.9	1.9	2.9	2.9	2.3	2.3	4.4	4.4	4.5	4.5	12.6	12.4	52.1	8.7	1.5	-			70.7	70.7	177.7	176.2	82.9	79.0	145.7	138.4	323.5	321.0	266.3	266.3	303.8	0.2	43.2	35.7	67.5	57.2
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	19.1	18.8	23.4	21.3	18.0	16.9	41.0	38.8	71.8	70.1	82.6	72.8	40.8	22.2	113.1	93.3	38.6	24.9	64.1	56.3	61.7	60.8	60.8	46.4	104.2	96.2	120.0	108.2	188.0	175.8	72.9	71.0	172.1	166.8	282.6	199.2
САНГИЙН САЙД	22.7	22.3	26.4	26.0	18.4	14.8	20.9	19.3	21.4	20.1	82.1	66.7	41.6	36.6	33.1	30.8	5.3	5.1	10.9	8.6	8.6	8.2	32.8	20.8	134.4	113.2	102.6	80.1	88.2	54.8	77.4	67.7	201.9	199.3	293.6	277.1
СОЁЛЫН САЙД	7.4	6.5	10.9	10.4	9.8	8.6	10.5	10.0	24.5	23.1	37.7	34.0	29.6	19.7	44.1	35.2	27.6	17.4	26.2	24.1	11.8	10.3	35.9	32.7	82.9	81.0	144.3	105.5	92.8	89.7	74.4	62.2	144.2	140.7	244.7	180.4
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	19.5	17.4	45.4	44.4	43.9	40.5	36.1	34.4	58.2	57.7	63.9	58.6	55.3	36.0	48.2	45.4	13.6	10.7	8.9	7.6	27.0	22.4	27.8	22.1	29.5	28.3	21.4	8.3	21.1	20.0	41.3	35.5	74.7	73.4	120.5	105.2
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	13.2	13.2	21.1	19.9	7.4	7.4	22.6	21.8	50.4	50.1	44.4	43.0	45.0	30.0	27.3	25.7	49.2	29.3	15.5	15.4	33.3	33.3	37.4	37.2	42.9	42.7	50.7	50.1	29.2	28.9	62.7	62.3	60.1	60.1	127.2	121.2
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	7.2	7.1	18.6	17.7	6.0	6.0	6.7	5.6	17.9	17.6	21.5	20.5	76.4	47.6	39.6	34.2	16.7	13.9	18.2	16.4	7.3	6.8	16.4	14.3	43.7	42.8	30.9	23.9	32.8	32.1	47.0	35.2			1.2	1.1
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	3.5	2.7	4.9	3.6	21.5	21.4	38.3	36.0	8.8	6.4	51.0	49.7	13.1	11.3	28.4	22.6	9.4	7.7	26.9	26.4	5.4	5.1	16.3	15.9	29.9	25.5	7.1	5.7	22.4	21.4	28.8	25.9	36.8	35.1	48.8	35.5
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	6.5	4.6	21.1	16.5	19.9	19.7	9.1	8.6	24.7	24.2	14.8	14.2	22.9	20.2	23.6	21.3	27.5	26.5	10.8	9.4	7.1	7.0	6.0	5.8	5.4	5.3	10.3	10.1	22.0	22.0	9.1	9.1	7.5	7.5	89.7	89.2
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЭГХЭГ-НИЙ ДАРГА	11.7	10.0	6.6	6.5	1.6	1.5	6.1	6.0	12.1	12.8	29.7	27.7	11.8	8.4	6.8	6.7	2.9	2.9	3.2	2.9	5.8	4.5	11.9	10.5	38.7	35.0	24.7	21.5	24.3	23.2	21.8	20.8	43.2	35.7	155.4	43.8
БАТЛАН ХАМГААЛАХ САЙД	2.6	2.6	25.3	25.2	2.0	2.0	3.3	3.3	18.0	18.0	15.9	14.6	17.7	13.9	30.1	27.8	4.5	3.1	5.9	4.9	4.9	4.9	3.6	3.3	15.5	15.3	9.0	9.0	6.2	6.1	12.5	12.4	11.9	11.9	55.8	55.6
НАХИМ ХӨГЖИЛ, ХАРИШЦАА ХОЛБООНЫ САЙД	9.3	9.3	0.6	0.5	2.4	2.4	11.0	7.1	18.8	18.7	21.7	20.8	28.2	18.4	38.0	29.4	1.1	0.2	1.7	1.7			3.3	2.2	14.2	13.8	22.1	21.1	6.1	5.0	6.4	5.7	21.6	21.3	16.4	5.3
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	2.8	2.8	6.5	6.5	2.6	2.6	3.4	3.3	31.9	30.1	36.3	35.3	4.5	4.1	9.3	6.9	1.3	0.9	1.0	1.0	0.8	0.7	10.4	10.2	13.8	12.1	17.6	14.7	18.0	16.8	17.8	15.5	18.5	18.0	20.5	18.4
БУСАД	7.1	6.3	18.6	15.2	10.8	10.7	17.6	17.4	48.8	45.8	23.6	22.0	44.5	37.9	26.6	23.7	6.9	6.6	3.4	3.4	7.0	7.0	9.8	9.4	23.1	20.5	20.5	18.8	38.7	36.7	29.5	330.9	677.6	633.2	229.7	168.8
НИЙТ	408.5	366.3	517.1	458.9	408.4	362.1	531.0	473.2	933.2	901.6	1,482.1	1,391.5	2,113.0	1,775.7	1,780.4	1,568.9	789.9	678.8	1,375.1	1,229.4	779.8	715.7	766.2	659.4	1,698.1	1,559.9	1,654.3	1,414.6	1,685.2	1,577.9	1,697.4	1,540.3	2,965.6	2,857.4	3,853.6	3,093.5